

ОВОО ТАХИЛГЫН ЯВЦ ДАХЬ ХОРИО ЦЭЭРЭЭС

У. ЭРДЭНЭТУЯА

МУБИС, Түүх Нийгмийн Ухааны сургууль, Монголын түүхийн тэнхим
erdenetuya@msue.edu.mn

Түлхүүр үг: овоо, тахилга, хорио цээр, монголчууд

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ. Энэ өгүүлэлд бид овоо тахилгын явцад мөрдөж ирсэн хорио цээрийн талаар авч үзлээ. Монголчууд тахиж шүтэж буй овоог дэргэд нь нэрээр нь дуудахыг цээрлэдэг ажээ. Мөн овоо тахилгын өглөө нар ургамал унтах, овоо руу уранхай хиртэй хувцастай, өргөх идээ ундаагүй гар хоосон очих, унаа малтай хамаагүй ойртох, төрийн хүмүүс, лам хуврагийн дээд талд суух, хад чулуун дээр сандайлж суух, архи дарс уух, балин тахил, идээ будаа руу дайрч, сувьдаглах, хэрүүл тэмцэл хийх, билээгүй муу үг хэлэх, санаа алдах, үйлж унжих, энгэр заамаа задгайлах ер нь аливаа зохисгүйг үйлдэх нь хориотой ажээ. Овоонд төрийн цаасан мөнгө, цаастай чихэр жимс, улаан мах, хонины сүү, халуун сүү өргөхийг хориглодог. Мөн уул овооны орчим хог хаях, мал нядалж улай гаргах, газар ухах, өөс ногоо зулгаах, мод хугалах хориотойн дээр ойр орчмын гол усанд биеэ угаах, ан гөрөө хийх, овооны орчим бие засахыг цээрлэдэг. Ихэнх овоонд эмэгтэй хүн гарч болохгүй гэдэг.

Овоо тахилгын явцад мөрддөг хорио цээрээс ажиглахад монголчууд өвөөг дээдсээсээ үе уламжлан шүтэж ирсэн газар усаа дээдлэх, газар усны эзэн лус савдгийг хилэгнүүлэхгүй байх агуулгаар хүндэтгэлгүй хайнга хандах явдлыг цээрлэдэг, тахилгын ариун газар гэсэн утгаар тахилгат овооны орчим аливаа бузар бүртгийг ойртуулахыг цээрлэдэг. тахилгат уул овооны орчмын нутаг нь ус ургамал, ан амьтан жигдэрсэн үзэсгэлэнт сайхан газар байдаг тул байгалиа хамгаалах агуулгаар ургамал амьтныг нь хөнддөггүй, овоо тахилгын зан үйл нь төрийн, нутаг хошууны, овог аймгийн, хэмжээний ёслол хүндэтгэлийн арга хэмжээ тул ёс горимгүй үйлдэл хийхийг чандлан хориглодог уламжлалтай байсаар иржээ.

Нүүдэлчин монголчуудын аж төрөх ухаан, хэв заншил, ёс уламжлал нь сав шимийн ертөнцөд хор хөнөөл учруулахгүй, эв зохицолтой аж төрөхийг сургадаг бөгөөд эдгээр нь төрийн ёс, шашны сургаал номлолоор агуулга нь улам баяжсаар иржээ. Үүний нэг жишээ бол овоо тахиx ёс бөгөөд энэ нь монголчуудын байгаль шүтлэгийн зан үйл, шашны зан үйл, төрийн ёслолын арга хэмжээ, тодорхой нутаг хошууны ард олны нийтээр хуран цугларч нутаг усандаа хүндэтгэл үзүүлэх ёсон, овог аймгаараа шүтдэг уул усаа тахиж, овог удмаа мэдэх ёсон гэх мэт дэлгэр агуулгатай, төр, шашин, ихэс дээдэс, ард олныг аль алиныг хамарсан зан үйлийн тогтолцоо юм. Энэ ч утгаараа овоо босгох газрыг сонгох, босгох, амилуулах, тахилгыг явуулах аливаа бүгдэд хэвшин тогтсон нарийн дэг горимыг баримталсаар иржээ. Мэдээж тэдгээр дэг горим нь түүхэн урт хугацаанд хувьсан хөгжиж

баяжсаар ирсэн болохоос бус аль эртнээс хэвшиж тогтчихоод эдүгээг хүрээд ирсэн зүйл биш нь ойлгомжтой.

Эртний хүмүүс байгалийн сүр хүчний өмнө сөхөрч, эрхшээлд нь автахын хамт, байгалийг өдөр бүр ажиглах явцдаа хүний амьдралын аливаа бүхэн байгалиас хамаарч буйг олж мэдэн, энэ нь улмаар байгалийг сахиусчлан шүтэхийн эхлэл болжээ. Дараа нь хийсвэрлэх сэтгэлгээ хөгжихийн хирээр тэнгэр, газар, ус, ургамлыг ялган салгаж ойлгох болж улмаар уул, усны эзэн сахиусны талаар төсөөлөл бий болжээ.

Монголчуудын уламжлалт ойлголтоор тахилгын овоо нь газар усны эзэд орших газарт тэдэнд зориулж босгосон орон гэр ажээ. Энэ талаар “Монгол зан аалийн ойлбор”-т “... Газар орны эзэд сахиулсныг тахих орныг өөрийн аймаг зуур сууж байх айл бүлгийн ойролцоо газар үзэж, чулуу буюу ургаж байх амьд модыг газар орны эзэд орших орон болгож тойрсон айл бүлэг зуур хавар намрын цаг тахиж шүтээн болгож явмуй” (Лувсанчойндон, 1981, 49-р тал) хэмээсэн байхад эрдэмтэн О.Пүрэв “...Усны эзэд аливаа усны эх булаг түрүүтэй газарт савдгийн газрын эздийн дээдэс уул толгодын оройд байрладаг учир лус савдгийн эздэд орон гэр болгон барьсан овоонуудын байрлал уулын оргил, рашаан ус, булаг шандын эхэнд байдаг...” (О.Пүрэв, 1999, 79-р тал) гэж тэмдэглэсэн байна.

Бурхны шашин Монголд дэлгэрснээр овоо нь лус савдгийн орон гэр гэсэн утгаас гадна Энэтхэг, Төвдөөс үүсэлтэй “Ертенцийн мод” “Ертөнцийн уул” хэмээх ойлголттой холбоотой болж, хэлбэр бүтцийн хувьд зарим өөрчлөлт орсон боловч овооны тахилгын зан үйл нь газар усны эздийг хүндлэн тахих гэсэн утгаа хэвээр хадгалж, тахилгын зан үйлийг бөө удирдан явуулдаг байсан бол лам нар явуулах болжээ. Хошуу нутаг, овог аймгийн хүрээний овоо тахилгын үндсэн агуулга ч дээр дурдсанаас төдийлөн зөрөөгүй юм. Төрийн хэмжээнд бол хөх тэнгэрт хамгийн ойр, сүрлэг өндөр уулнаа овоо босгон, хөх мөнх тэнгэрээ хөрс этүгэн эхийн хамтаар тахиж төр төвшин, ард олон амгалан, жаргалтай, элбэг баян байхыг даатгадаг.

Бид энэ удаа овоо тахих ёсны талаар тоочихыг бус тахилгын явцад цээрлэх цөөхөн зүйлсийн тухай авч үзэхийг зорилоо.

Юун түрүүнд тахиж буй овоо эсвэл тухайн овоо байрлаж буй уул, усны нэрийг хэлэхээс цээрлэнэ. “Отгонтэнгэр уул” гэлгүй “Богд Очирваань хайрхан”, “Дарь Овоо” гэхийн оронд “Алтан Овоо”, “Онон гол” бус “Хатан ижий” гэх мэтээр хүндэтгэн дууддаг. Энэ нь нэг талаас монголчуудын байгаль дэлхийгээ эцэг эхтэйгээ зүйрлэн хүндэтгэдэг сэтгэлгээтэй холбоотой бөгөөд монгол хүн эцэг эхээ

нэрээр нь дуудахыг цээрлэдэг лугаа адил зүйл юм. Мөн газар усны эзний сүр хүчнээс эмээсэндээ дээрх мэтээр нэрийг нь эерүүлэн дууддаг.

Овоо тахилгын үед цээрлэх, чандлан мөрдөх зүйлс дотор хэв хуулийн шинжтэй зүйлс нилээд олон тохиолдох ажээ. Үүний жишээ дурдвал:

Тахилгын өглөө нар ургатал унтдаггүй тул эртлэн босч, цай сүүнийхээ дээжийг өргөөд, гоё сайхан хувцсаа өмсөж үс гэзгээ янзлан гоёж гооддог. Хэрвээ үүнийг эс тоомсорловол уул усны эзэн савдаг хүндэтгэл үзүүлээгүйд хилэгнэж, улс орон, хүн малд гай зовлон тохионо, ёсоор нь хичээнгүйлэн гүйцэтгэвэл лус савдаг баярлана гэж итгэдэг байна. Мөн төр, шашин, ёс заншлаа дээдэлж буйн илрэл юм.

“Тахилгын овоо руу унаа малтай хамаагүй ойртож болохгүй, морь мал, унаа хөсгөө зайдуу орхиод овоонд явган хүрч очдог. Түүнчлэн тахилгад явахдаа өл халзан морь унаж очдоггүй. Ийнхүү очоод сүсэгтэн олон төрийн хүмүүс, лам хуврагийн дээд талд суух ёсгүй бөгөөд суудлын зиндааг чанд баримталдаг нь ёс төрөө дээдэлж, буйн зэрэгцээгээр энгийн ардад хүнддэж магадгүй гэж үздэгтэй холбоотой. Мөн хад чулуун дээр сандайлж суухыг цээрлэдэг байна. Биеэ хэрхэн биеэ авч явахтай холбоотой хорио цээрээс дурдвал, архи дарс уух, балин тахил, идээ будаа руу дайрч, сувьдаглах, хэрүүл тэмцэл хийх, билэггүй муу үг хэлэх, санаа алдах, уйлж унжих, энгэр заамаа задгайлах ер нь аливаа зохисгүйг үйлдэх нь хориотой бөгөөд их халууцсан тохиолдолд зөвхөн дөчөөс дээш насны хүмүүс дээлээ сугалдаргалж болдог байна. Тахилгын явцад тахилгыг эрхлэн явуулж буйгаас бусад бүх хүмүүс ноён түшмэл, харц ард ялгаагүй аливаа үйлдлийг дур мэдэн гүйцэтгэх хориотой ажээ. Жишээ нь сан тахилгын судар уншсаны дараа уул овоондоо мөргөж, дараа нь идээ будаагаа өргөх ба цацлын судрыг уншсаны дараа сүү, шимээ өргөхөөс бус өмнө нь дур мэдэн аливаа идээ будааг өргөдөггүй. Хэрвээ дээрх дэг ёсыг зөрчвөл тахилга хүчингүй болно гэдэг. Овоонд даатгал хүсэл тавихдаа эхлээд өөрийн төлөө бус бусдын сайн сайхны төлөө даатгах нь илүү буян хураана”(Лувсандаржаа, Түвдэндовдан, 2003, 2-3-р тал) гэж үздэг байна.

Тахилгад оролцох хүмүүс заавал овоондоо өргөх идээ цагаатай очих ба гар хоосон, уранхай ноорхой хувцастай очих нь тухайн хүн өөрөө төдийгүй, гэр орон үр хүүхэд нь, цаашлаад нутаг орон нь үгүйрч хоосорно гэдэг. Овоо тахилгад оролцож буй хүмүүсийн хамгийн цээрлүүштэй зүйл бол овоонд чулуу өргөхгүй байх явдал ажээ.

О.Латтиморе Өвөр Монголын Сөнидийн овоо тахилгын талаар: “Монголчууд бүгдээрээ овоондоо гүн хүндэтгэл бишрэлтэй ханддаг ч овоо тахилгын үед тахилгын зан үйлийн талаар нэг бүрчлэн тайлбарлах хүнтэй тааралдсангүй”

(Lattimore, 1941) хэмээн тэмдэглэсэн байна. Энэ нь монголчууд овоо тахилгын талаар мэдэхгүйдээ бус тахилгын явцад түүний талаар хэлж ярихыг цээрлэдэг байж болох талтай.

Овоонд өргөхийг хориглодог зүйлийн тоонд төрийн цаасан мөнгө, цаастай чихэр жимс, улаан мах, хонины сүү, халуун сүү зэрэг багтдаг бөгөөд эдүгээ хог болох зүйлээ овоонд “өргөдөг” нь маш зохисгүй, ёс журамгүй үйлдэл болно. Хэрвээ улаан мах өргөвөл хэл ам ширүүсч, хуй салхи босон, газрын хөрс хатах ба дайн дажин тохионо гэж үздэг. Халуун сүү өргөвөл ган болох, хонины сүү өргөвөл яр шарх нэмэгдэнэ, эх үрсийн энх амгаланд халтай гэж үздэг байна.

Тахилгатай уул овооны орчим хог хаях, мал нядалж улай гаргах, газар ухах, өвс ногоо зулгаах, мод хугалах хориотойн дээр ойр орчмын гол усанд биеэ угаах, ан гөрөө хийх (мөн овоо тахилгаас буцах замдаа айл хэсэх, ан гөрөө хийх цээртэй), овооны орчим бие засахыг цээрлэдэг. Дээр үед тахилгад оролцохоор ирсэн хүмүүс гүзээнд бие засдаг байжээ. Одоо үед тахилгат овооны орчим хүмүүс жижиг овоо босгодог нь ариун дагшин газрын чулууг ховхолж болдоггүй гэсэн утгаараа буруу зүйл ажээ. Энэ талаар Лувсанчойндоны “Монголын зан аалийн ойлбор”-т: “Овоог тахисан учир болбоос их эрт цаг тэнгэрийг шүтэж уул усанд аливааг даатган явж байсан цаг, олноор чуулга болж уул буюу их мөрөн гол буюу эс бөгөөс их нуур буй эдгээр газрыг сонгож тахилгын орон болгож, их хүндэтгэмүй. Хэрвээ нуурыг тахисны хойно хэрхэвч тахьсан нуурын загас амьтныг хүнээр бариулж огт болохгүй цээрлэмүй. Уулыг тахиж шүтсэн хойно чулуу мод шороо өвсийг хөдөлгөхгүй бөгөөд авч хэрэглэхгүй буй амуй” (Лувсанчойндон, 1981, 292-р тал) гэжээ. Энэ нь нэг талаас төрөө уламжлалаа хүндэтгэх хүндэтгэлийн агуулгатайгаас гадна нөгөө талаас байгаль орчноо хамгаалах агуулгатай хорио цээр юм. Аливаа тахилгат овоог байгалийн тогтцын хувьд ан амьтан, ус ургамал тэгширсэн, газарзүйн хэд хэдэн бүсийн зааг, ойр орчны гол мөрний эх болох гол зангилаа газарт босгосон байдаг.

Богд хаант Монгол улсын үеийн “Зарлигаар тогтоосон монгол улсын хууль зүйлийн бичиг”-т тахилгат уул овооны орчим мод огтлох, гөрөөлөхийг хуульчлан цаазалсан байна. Энэ талаар уг хууль зүйлийн бичгийн *Цаазласныг зөрчих нь хэмээх жаран дөрөвдүгээр дэвтэрт* “Тайлга бүхий эрхэмсэг ууланд гөрөөлөх, мод огтлохыг цаазлах” хэмээх заалтад: “Нэгэн зүйл: Аливаа зарлигаар тайх эрхэмсэг ууланд гөрөөс гөрөөлж, мод огтолж болохгүй. Хэрвээ цаазласныг зөрчиж, хулгаж гөрөөлөх хэрэг гарч баригдаад, гөрөөс алсан үгүй болбоос битүү хулгай хулган явж, эд олсон үгүй хууль ёсоор нэгэн зэрэг нэмүүлэн шийтгэ. Хэрэв гөрөөс алсан

нь буга, гахайн зэрэг болбоос их малд адилтгаж, зүр, зээр, чоно, үнэг, тарвагын зэрэг болбоос хонинд адилтгаж, цөм битүү хулгай хулган явж, эд олсон хууль ёсоор ялган салгаж, нэгэн зэрэг нэмүүлэн шийтгэ. Бас хулган явж мод огтолбоос, битүү хулгай хулган явж, эд олсон эс олсныг ялган салгаж, эдийг бодож, хууль ёсоор нэгэн зэрэг нэмүүлэн шийтгэ. Агнаж олсон зүйл, огтолсон мод, жич, унасан морь, буу зэвсгийг цөм албанд оруул. Осол сул захирсан харьяат занги, даргыг цөм тус тус 5 малаар торго. Байцаахыг алдсан цагдааг 80 ташуур занчигтун” (О.Батсайхан ба бусад, 1995, 232-233-р тал) хэмээжээ.

Овоо тахилгад холбоотой өөр нэг цээр бол тухайн овоонд эмэгтэй хүн гарах, эс гарахтай холбоотой цээр юм. Овоонд эмэгтэй хүн гарч болохгүй гэдэг цээр нь нилээд харьцангуй бөгөөд судлаачид ч энэ асуудлыг өөр өөрийнхөөрөө тайлбарладаг. Эхийн эрхт ёсны үед овоо тахих зан үйлийг удган эрхлэн явуулдаг байгаад эцгийн эрхт ёсны үеэс уг зан үйлийг бөө явуулах болжээ. Гэвч урт хугацааны туршид бөө удган аль аль нь тэнгэр, уул хайрханаа тахих зан үйлийг гүйцэтгэсээр иржээ. Бурхны шашин монголд дэлгэрснээр овоо тахих зан үйлийн хэлбэрт өөрчлөлт орж эмэгтэй хүн овоонд гарахыг ерөнхийд нь хориглох болжээ. Үүний учрыг тодруулахад овоо тахилгад түгээмэл уншигддаг “Ариун сан” нэрт судрууд тодорхой хэмжээгээр тус дөхөм болох болов уу. “Ариун сан” судрын нэгэн хувилбарт:

“Сарын бэлгэ цуварсан

Самуун гэмд шунасан (ariun sang orusiba, УТНС 5233/96) эмэгтэй хүн тахилгын ариун газар очихыг хориглоно гэсэн агуулгатай мөр буйгаас насанд хүрсэн... эмэгтэй хүн овоонд гарах чанд хориотой нь харагдаж байна. М.Сайнжаргалын “Монгол тахилга”-даа арван гурван нас хүрээгүй охид эцэг эх, ах ихсийг дагуулж овоонд гарч (М.Сайнжаргал, 2001, 547-р тал) болдог талаар дурджээ. Н.Л.Жуковская “Ламаизм и ранние формы религии” (Н.Л.Жуковская, 1977, стр-43) зохиолдоо 18 хүртэлх насны охид овоонд гарч болох талаар дурдаад, түүнээс дээш насны бүсгүйчүүд зөвхөн овоо тахилгын наадамд оролцож болох талаар тэмдэглэжээ. Эндээс 13 нас хүрээгүй болдог гэсэн нь үнэнд илүү ойр дөт байна.

Овоонд эмэгтэй хүн гардаггүй өөр нэг тохиолдол овог аймгаар тахидаг овооны тахилгын явцад илэрдэг. Энэ талаар В.А.Казакевич Дарьгангаар зорчсон тэмдэглэлдээ “Овоо нь тухайн овог аймгийн тахилга шүтлэгийн ариун газар тул эхнэр хүн харь овгоос ирсэн гэсэн утгаараа овоонд гардаггүй, энэ ариун дагшин газрыг бузарласныхаа төлөө үхэл зовлонд учирна гэж үздэг” (В.А. Казакевич, 1930,

стр-59) хэмээн дурджээ. Энэ дашрамд уул, овоонд эмэгтэй хүн гарах хориотой гэдэг нь нэг талаас эцэг тэнгэртээ ойр очиж болохгүйтэй (Чимэдцэрэн, 54 нас), нөгөө талаас аливаа тахилгатай уул овоо нь хаан ноён, баатар эрс, өвгөн буурал, бичгийн мэргэдийн дүр бүхий (эр) эзэн савдагтай байдагтай холбоотой болов уу. Гэвч эмэгтэй хүн гардаг уул овоо цөөнгүй бий.

М.Сайнжаргалын бичсэнээр эмэгтэй хүмүүсээс гадна овооны тахилгыг сохор, дүлий, эрэмдэг зэрэмдэг хүмүүс хөтлөн явуулах нь цээртэй төдийгүй, мөн зарим нутагт үр хүүхэд төрүүлдэггүй эмэгтэй хүнийг ч тахир дутууд тооцож овоо тахилгад оролцуулахгүй байх тохиолдол байдаг (М.Сайнжаргал, 2001, 548-р тал) ажээ. Түүнчлэн гэр бүлд нь үхэл хагацал болоод 49 хоног нь өнгөрөөгүй хүн, ял зэм эдэлж дуусаад жил болоогүй хүн, нутаг оронд нь өвчин тахал гараад хөл хорионд буй хүн овоо тахилгад оролцох цээртэй гэдэг. Гэр бүлд үхэл зовлон тохиогоод удаагүй байгаа хүн овоо тахилгад очдоггүйн учир нь "Ариун сан"-д дурдсан ёсоор "Үхэгсдийн хүүрийн бузар бэлэвсний харшийн бузар"-тай зарим талаар холбоотойгоос гадна уй гашуу тохиолдоод удаагүй үед аливаа баяр ёслолд оролцохыг цээрлэдэг монгол дэг ёстой холбоотой. Ял зэм эдэлж дуусаад удаагүй буй болон хэрэг төвөгт холбогдсон хүн биеэр болон сэтгэлээр нүгэл үйлдсэн бузартай буюу бузар нь арилаагүй байгаа гэсэн утгаараа тахилгын ариун газар очих хориотой юм.

Дүгнэж хэлэхэд, энэ удаа бид овоо тахилгын явц дахь хорио цээрээс цөөхөн баримтад тулгуурлан тойм төдий авч үзлээ. Цаашид овоо тахилгын төрөл, цар хүрээ, нутаг орны байдал зэргээс хамаарч ямар өвөрмөц онцлог бүхий хорио цээр тогтсон талаар нягтлууштай юм. Гэхдээ, өвөг дээдсээсээ үе уламжлан шүтэж ирсэн газар усаа дээдлэх, газар усны эзэн лус савдгийг хилэгнүүлэхгүй байх агуулгаар хүндэтгэлгүй хайнга хандах явдлыг цээрлэдэг, тахилгын ариун газар гэсэн утгаар тахилгат овооны орчим аливаа бузар бургтийг ойртуулахыг цээрлэдэг, тахилгат уул овооны орчмын нутаг нь ус ургамал, ан амьтан жигдэрсэн үзэсгэлэнт сайхан газар байдаг тул байгалиа хамгаалах агуулгаар ургамал амьтныг нь хөнддөггүй, овоо тахилгын зан үйл нь төрийн, нутаг хошууны, овог аймгийн, хэмжээний ёслол хүндэтгэлийн арга хэмжээ тул ёс горимгүй үйлдэл хийхийг чандлан хориглодог зэрэг нь тахилгын цар хүрээ, нутаг орны онцлогоос үл шалтгаалан бүх монголчуудын хувьд нийтлэг юм.

НОМ ЗҮЙ

- Ariun sang*. УТНС-ийн гар бичмэлийн фонд, 5233/96. х. 10
Батсайхан.О, Лонжид.З, Хажидсүрэн.Ч (хөрвүүлсэн).1995. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг, Улаанбаатар хот. х. 274
Жуковская.Н.Л., 1977. Ламаизм и ранние формы религии. М. с.193
Казакевич.В.А., 1930. Поездка в Даригангу. Л. с.130
Лувсандаржаа, Түвдэндовдан, 2003. Сүсэгтэн та бүхэн минь болгооно уу. Улиастай. х. 6
Лувсанчойндон, 1981. Монголын зан аалийн ойлбор. Хөх хот. х. 369
Пүрэв О., 1999. Монголын бөөгийн шашин. Улаанбаатар. х. 392
Сайнжаргал М., 2001. Монгол тахилга. Хөх хот. х. 615
Lattimore.О., 1941. Mongol journeys /Obo sacrifice and Obo games/. London. p. 230

SUMMARY

U.Erdenetuya

PROHIBITIONS DURING OBOO WORSHIP CEREMONY

In this paper we have attempted to demonstrate some outlines of prohibitions, followed during an oboo worship ceremony, irrespectively local custom and traditions, worship ceremony scope and types.

Various prohibitions are followed by the Mongols, related to oboo, such as, to get up late on oboo worship day, sprinkle hot milk to the oboo, do voluntary ritual action, be dressed in rags, to quarrel or curse, litter, cut grasses, touch stones around the oboo. Besides these, if someone died just recently (up 49 days), her or his relatives and family members are not allowed to attend the oboo worship rite.

In general, all the Mongols disagree with any careless attitude towards the earth and the water, as well as venerated oboo, because of their consideration of Earth – like a Mother, Sky - Father. Due to the Mongols' view, guardian geniuses of the earth and the water (*luus, savdag*) gather around worshipping oboo, accordingly, if anyone did wrongful deed, quarreled, polluted the site and so on, these geniuses would disagree and consequently will bring misfortunes. A worshipping oboo is sacred site of the locality or the state, therefore, people avoid to profane the extreme sacred site. An oboo worship rite is state, banner or tribal ceremony in profound homage, in this sense, they are prohibited to be done any immoral and impolitic action by not only commoners, also dignitaries.

It is common that, a venerated oboo is located in beautiful place, where the landscape combines steppe, hills, mountains, fertile soil, thick-grass land, lakes, rivers, springs of pure mineral water, sand, trees, animals and plants. Traditionally, Mongolians protect such places through worship and veneration, as well as through laws and rules.